

Нэгдсэн Үндэстний Байгууллагын шинэчлэл ба Герман улс

ХБНГУ-ын Тюбингений Их Сургуулийн
докторант М.Туяа

Германы улс төр судлаачдын дунд өрнөж буй маргааны нэгэн чухал сэдэв бол НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл(АЗ)-д орох Германы хүсэл мөн боломжийн тухай юм. Энэ өгүүлэлд Германы зарим томоохон улс төр судлаачдын үзэл бодлыг авч үзэхийн хамт НҮБ-ын шинэчлэлд хандаж буй Германы бодлого чиглэлийг тодорхойлохыг зорьсон болно.

Герман улс нь цэрэг зэвсгийн хүчийг ашиглан үй олноор нь улс түмнийг устгасан дайны аюул, цэргийн дэглэмийг туулж өнгөрүүлсэн улс билээ. Дайны дараагаар өөрийн бүс нутагт ил болон далд аргаар улс төрийн давамгайлалд үл тэмүүлэх амлалт авсан. Гэвч тавин жилийн дотор Герман улс нь дэлхийн тэргүүлэгч хөгжилтэй улс болсон ба НҮБ-ын АЗ-ийг өргөтгөн, байнгын гишүүн болох зорилтод хүрэхийн тулд хийсэн алхмуудыг¹ дурдвал:

1. Герман улс нь 1980-аад оны дунд үеэс эхлэн НҮБ-ын системийг шинэчлэх чиг шугамыг барьсан идэвхитэй үйл ажиллагааг явуулж эхэлсэн юм. Үүнд байгаль орчныг хамгаалах, зэвсэглэлээр үл хөөцөлдөх, зэвсэг хураах үйл ажиллагаа зэрэг дэд секторуудад идэвхитэй оролцож байна.
2. 1990, 1991 оноос өөрийн зэвсэгт хүчнийг олон улсын үүрэгтэй болгох бодлогод анхаарлаа хандуулж, улмаар 1994, 1998 онд гадаадын аль нэгэн улсад цэрэг оруулахыг хориглодог байсан Үндсэн хуулийнхаа заалтад өөрчлөлт оруулснаар одоогийн энхийг сахиулах хүчинд (peace-keeping operation) Герман улс оролцох болсон. 1998 онд АНУ-тай байгуулсан Аюулгүй байдлын гэрээгээ шинэчилж SDF (Self Defence Forces) буюу өөрийгөө хамгаалах хүчний хамтын ажиллагааг хуульчилсан бөгөөд үүнтэй нэгэн адил хувилбараар НАТО-гийн холбоотны хувьд "out of area" бодлогын хүрээнд тэгш эрхтэйгээр оролцсон. Энэ нь аюулгүй байдлын сонирхлоо тодорхойлоход том алхам болсон. Мөн НҮБ-ын АЗ-ийн цэрэг зэвсгийн хүчээр албадах арга хэмжээг хэрэгжүүлэхэд

- мандат олгодог шийдвэрийг легитимчлэх асуудалд анхаарч ирэв. Герман улс нь НАТО болон НҮБ-ын цэргийн хүчний өрсөлдөөнийг гүүр болж холбох, зөөлрүүлэх үүрэг гүйцэтгэж байна² (M.Knapp).
3. Хоёрдугаар дайнаас хойш үүссэн Германд үл итгэх хөршүүдийн хандлагыг олон улсын хамтын ажиллагаанд идэвхитэй оролцож буй нэр хүнд, байр сууриараа итгэл олох замаар арилгаж чадсан (reserves of confidence).
 4. Герман улс өөрийгөө худалдааны болон иргэний улсын гадаад бодлого (handels- oder zivilstaatliche Aussenpolitik) хэрэгжүүлэгч улс гэж гадаад ертөнцөд ойлгуулахыг зорьж байна. Үйлдвэрлэл, санхүүгийн хүчин чадлаараа нөлөө бүхий барууны хэмээх хөгжингүй улсуудын тоонд зүй ёсоор байр сууриа эзэлсэн.
 5. Хүчний тэнцвэрт харилцааг (Balance of power) олж авахдаа цэрэг зэвсэглэлийн бус бүс нутгийн хамтын ажиллагаа, Европ дахь интеграцчиллын бодлогыг ашигласан.

НҮБ дэх Германы гишүүнчлэл 1952 онд элсэх өргөдөл өгч, 1973 оны 9 дүгээр сарын 18-нд гишүүн болсноор эхэлсэн. Баруун Герман 1977/78, 1987/88 онд, Зүүн Герман 1980/81 онд харин Нэгдсэн Герман 1995/96 онд АЗ-ийн байнгын бус гишүүнээр тус тус сонгогдож байсан. 1990 оны 10 дугаар сарын 3-нд хоёр Герман нэгдэхэд Нэгдсэн Германы НҮБ-д чиглэсэн бодлогын шинэ үе эхэлснээр арвандолоон жилийн турш үргэлжилсэн хоёрдмол гишүүнчлэл эцэс болсон. Шинэ бодлогын үе нь НҮБ хямралд орж эхэлсэн яг тэр үетэй давхцадаг тул шинэчлэлд өдийг хүртэл өндөр ач холбогдол өгч байна. 1991 онд анх Бундестагийн дэргэд НҮБ-ын бодлогыг тодорхойлох дэд хороо байгуулсан нь уг асуудлыг дээд түвшинд авч үзэхийн эхлэл байв.

АНУ 1994 оны хавар анх удаа Герман, Япон хоёрыг АЗ-д байнгын гишүүний статустайгаар авах өргөдөл өгсөнөөр Ерөнхий Ассамблейн 47 дугаар чуулган дээр энэ асуудлаар санал хураалт болсон юм³. Токио, Бонн хоёр НҮБ-ын 50 жилийн ойгоор АЗ-д орох болов уу хэмээн хүлээж байсан нь талаар болсон. Хэрэв НҮБ-д оруулж буй татвар нь АЗ-д оруулах нөхцөл байсан бол одоогийн АЗ-ийн орнуудаас ч өндөр татвар төлдгийн хувьд, мөн эдийн засгийн хүчирхэг байдлаар нь ч авч үзсэн Герман улс АЗ-д түүртэлгүй орох байсан. Гэвч үл зөвшөөрөх шалтгаанууд⁴ тухайн үед байсан. Үүнд:

1. НҮБ-ын дүрмийг өөрчлөх шаардлага гарч ирнэ. Гэвч НҮБ-ын дүрмийг өөрчлөх нь боломжгүй зүйл үү гэвэл үгүй юм. 1965 онд НҮБ-ын дүрмийн 23 дугаар зүйлд өөрчлөлт орж, АЗ 11 гишүүнтэй байсныг 15 болгосон. 1968 онд 109 дүгээр зүйлийг өөрчилж НҮБ-ын дүрэм өөрчлөх асуудлыг хэлэлцэх ерөнхий бага хурлыг хуралдуулах асуудлыг АЗ-ийн 7 гишүүний саналаар шийдвэрлэдэг байсныг өөрчилж, 9 гишүүний саналаар шийдвэрлэж байхаар болжээ. Мөн дүрмийн 109 дүгээр зүйлд цаг үеийн байдлыг тусгасан өөрчлөлт оруулж байх талаар тодорхой заасан. Оруулсан өөрчлөлт нь хүчин төгөлдөр болохын тулд НҮБ-ын бүх гишүүний 2/3-ын саналыг авч, мөн 2/3-ын олонхиор батлагдах ёстой. Мөн АЗ-ийн байнгын 5 гишүүн тавуулаа зөвшөөрсөн байх учиртай. Тэгэхээр НҮБ-ын дүрмийг өөрчлөх нь процедурын хувьд хялбар зүйл биш юм.
2. Герман улсыг АЗ-д элсүүлэхэд байнгын 5 гишүүн улс санал нэгдэх ёстой. Гэтэл одоог хүртэл дээрх 5 улсын нэгдсэн дэмжлэг үгүй байна. НҮБ-ын практик үйл ажиллагааг шинэчилж зохион байгуулъя гэвэл хүйтэн дайн дууссаны дараа үүссэн шинэ нөхцөл байдалд тохируулан хэлэлцүүлэг, маргаан үүсгэж ярилцах шаардлагатай бөгөөд эдгээр улс уруу чиглэсэн үр ашигтай дипломат арга зам хамгийн чухал юм.
3. Герман улсыг АЗ-д элсүүлэх нь АЗ-ийн байнгын бус гишүүн орнууд ба бусад гишүүдийн хувьд маш чухал, эн тэргүүний, тулгамдсан асуудал болж харагдахгүй байсан зэрэг шалтгаанууд байна. Тэдгээр орнууд (мэдээж ихэнх нь хөгжиж буй улсууд) өөрсдийн тулгамдсан асуудлаас илүүтэйгээр АЗ-ийг өргөтгөх асуудалд ач холбогдол өгөхгүй л байсан болов уу. 1994 онд Нидерланд, Америк хоёроос өөр энэ саналыг дэмжих голлох улс байсангүй. Бусад улсууд IÅND болон Европын бус улсыг сонгохыг хүсч байв. Тэгэхээр АЗ-ийг өргөтгөх санал дэмжигдсэн ч харин хэнийг сонгох вэ гэдэг дээр маргалдаж байсан түүхтэй.⁵

Гэвч Иракт хийсэн Америкийн дайны дараа (мөн Югославийн хямрал болон бусад) гүн хямралд ороод ганхаж буй НҮБ-ыг яах аргагүй шинэчлэх хэрэгтэйг гишүүн улсууд бүх түвшиндээ ойлгосон болов уу.

Улс төр, шинжлэх ухаанд Олон Улсын Хамтын Нийгэмлэг гэж ярьж байвал энэ нь зөвхөн НҮБ бөгөөд 189 гишүүний статусаараа харьцангуй бүх дэлхийн шинж чанартай байгууллага юм. Хүйтэн дайн

дуусч шинэ дэг журам тогтох үед НҮБ-ын хийх алхмуудыг ажиглаж, түүнийг дэлхийд ирээдүйн дэг журмыг тогтооход нэгэн гол оролцогч болно гэж үзэж байсан. Гэтэл мөн НҮБ-ын үүрэг роль дуусчээ хэмээн үзэх судлаачид ч олон болжээ.

НҮБ яагаад хямралд орох болов гэсэн асуудал энд тулгарна. НҮБ-ын шинэчлэлийг улс орон бүр өөрийнхөөрөө төсөөлж буй ч Германы судлаачид үүнийг хэрхэн үзэж, ямар бодлого боловсруулж байгаа талаар бага боловч өгүүлэх нь энэ өгүүллийн зорилго юм.

1. НҮБ-ын хамтын аюулгүй байдлын систем

НҮБ-ын мөргөлдөөнийг зохицуулах, энхийг сахин хамгаалах арга ажиллагаа, хамтын аюулгүй байдлын систем шүүмжлэлд хамгийн их өртөж байна.

Анх 1945 онд байгуулагдахдаа хамтаар аюулгүй байдлыг хангах системийг байгуулсан нь дүрмийн 7 дугаар бүлэгт зааснаар дэлхий нийтийн аюулгүй байдал, энх тайванд заналхийлсэн нөхцөл үүссэн үед АЗ-ийн байнгын 5 гишүүний авч хэрэгжүүлэх хамтын аюулгүй байдлын систем юм. Тэр үеийн нөхцөл байдалд хамтын аюулгүй байдлын систем гэдгийг их гүрнүүд ч мөн бусад гишүүн орнууд ч хүлээн авах чадваргүй байсан. Ингээд бүх гишүүн улсууд тэгш эрхтэй гэж тунхагласан. Хамтын аюулгүй байдлын систем нь аливаа нэгэн улсын аюулгүй байдалд заналхийлэгч талын эсрэг хүч хэрэглэхдээ заналхийлэгч улсын үндэсний ашиг сонирхол, цэрэг, эдийн засгийн чадавхи ирээдүйд алдагдаж, доройтох уршигтайг ч харгалзан үздэггүй. НҮБ-ыг үүсгэн байгуулах үед гол гүрнүүд хэрхэн тунхаглаж байсан хийгээд үүнийг өнөөг хүртэл хийсэн шинэчлэлийн бодит үр дүнтэй харьцуулан үзвэл эмпирик зорилгодоо хүрэхийг тэмүүлээгүй ажээ.

Тухайн үедээ их гүрнүүд дэлхийн энх тайван аюулгүй байдалд санаа тавьдаг дэлхийн цагдаагийн үүргийг хамтран хүлээхийг хүссэн (Рузвельт) ба энэ нь хэрэгжээд, өнөөдөр НҮБ-ын аюулгүй байдлын систем нь АЗ-ийн байнгын 5 гишүүн ба бусад их гүрнүүдийн *хамтын манлайллын* (collective hegemony) нэг хэлбэр л болжээ. (Czempiel 1994) Энэ нь АЗ-д оруулсан асуудлыг шийдэхэд мөн энхийг сахиулах хүчнийг хааш нь илгээх вэ гэдгийг дээрх манлайллын хэлбэрээр шийддэг гэсэн үг юм.

Алив нэгэн улс их гүрэнтэй ашиг сонирхлын үүднээс холбоотны бодлогоор холбогдсон бол тухайн улс тодорхой хэмжээгээр аюулгүй байдлын баталгаатай болно. Нэг том гүрний батлан хамгаалах

холбоонд орох нь НҮБ-ын хамтын арга ажиллагааг авснаас илүү бодитой зүйл болжээ. Тэгэхээр энэ нь яах аргагүй НҮБ-ын дүрмийн утга, үг үсэг нь билээ. Энхийг сахиулах хүчний одоогийн шинэ байдал нь энхийг тайван замаар тогтоох бус харин НҮБ-ын дүрмийн 7 дугаар бүлгийн хүчээр албадах (peace enforcement) арга хэлбэр болж хувирсан юм. Өөрөөр хэлбэл “энх тайвныг” тогтоохдоо АЗ-ийн шийдвэрийн үндсэн дээр хямрал, мөргөлдөөнд *сонгомол* (selective) байдлаар үнэлэлт өгч, ялгавартайгаар хандаж, дайн хийх нь АЗ-ийн энхийг тогтоох арга ажиллагааны цөм болсон байна (Czempiel, Link). 1945-2003 онд гаргасан АЗ-ийн 1000 гаруй шийдвэрийн 1/3 орчим нь зөвхөн АЗ-ийн нэг гишүүн татгалзсанаар амжилтгүй болж байжээ. Тэгэхээр жинхэнэ утгаар аюулгүй байдал, энх тайвны баталгаа байхгүй гэсэн үг болж байна.

Хүйтэн дайны дараагаар хориг тавих явдал буурсан нь гишүүд тохиролцоонд хүрч чадахгүй бол уг асуудлыг суртал ухуулгын чанартай ашиглах шаардлагагүй тул ерөөс түүнийг авч хэлэлцэхээс түдгэлзчихдэг болсонтой холбоотой. Хэрэв аль нэг асуудал байнгын 5 гишүүний ашиг сонирхолын бүсэд нэвтэрвэл *ad hoc* онцгой хороо, шүүх гэх мэтийг байгуулдаг. Ингэснээр нэгдүгээрт: санхүүжилт олох бөгөөд хоёрдугаарт: хамтын манлайллын хэлбэр нь албан ёсны болж хуульчлагдана. АЗ-ийн байнгын гишүүн их гүрэн *Ad hoc* олон улсын шүүхүүдэд өөрсдийн болон гадны нутаг дэвсгэр дээрх үйл явц, хориг арга хэмжээнийхээ төлөө хариуцлага хүлээхээр байсан ч, ямар ч тохиолдолд дуудагдахгүй мөн шийтгэл хүлээхгүй өнгөрдөг. Ирээдүйд ч ийм байх болов уу. Хориг тавих эрхийн дагуу их гүрэн, түүний холбоотон улсууд (НҮБ-ын Дүрмийн 51 дүгээр зүйл) ял зэмлэлээс давхар хамгаалагдах тогтолцоо бүрджээ. (IFOR, SFOR үүний жишээ) 1990 оноос хойш мөргөлдөөн гарах явдал өсөх хандлагатай болсон нь АЗ-ийн *хүчний монополь* үр ашиггүй байгааг харуулж байна. Мөн нэгэн шинэ хандлага бол их гүрнүүдийн нэг нь хэт бие даасан манлайллын бодлого хэрэгжүүлж буй нь АЗ-д, НҮБ-ын хүрээнд хэзээ ч тэнцвэрт байдал бий болохгүй юм. (Иракийн хямрал 2003)

Их гүрний цэргүүд энхийн ажиллагаанд оролцоход цэргийн арга ажиллагааг Дүрмийн 42 дугаар зүйлийн дагуу аль болох хязгаарлах, цэргийн ажиллагааг нээлттэй байлгахыг шаарддаг учраас бүхий л арга ажиллагаа дүрмийн гадуур тайланд тусгахгүй байхаар хийгддэг.

1992 онд АЗ-ийн улсууд дээд хэмжээнд хуралдаж, Ерөнхий нарийн бичгийн даргын гаргасан Agenda for peace хэмээх баримт бичиг

гарган, үүнд аюулгүй байдлын гол үүрэг хариуцлага нь дэлхийн энх тайвныг хангах, түүнийг үр дүнтэй хамгаалах явдал гээд НҮБ-ыг олон улсын харилцааны нэг том оролцогч болгох санал тавьж байв. Энхийн төлөөх мөрийн хөтөлбөрийн зорилго бол НҮБ дээд удирдлага нь байхаар нэгдсэн цэргийн хүчин байгуулах, түүнийг хэрэгжүүлэх явдал юм. Гэвч энэ хүчинд зориулж НҮБ-ээс гаргасан зардал нь Нью-Йоркийн цагдаагийн газрын төсвөөс ч илүү байж чадахгүй тул энэ төсөл хэрэгжих бодит үндэслэл бага юм

Тэгэхээр эцсийн бүлэгт НҮБ-ын аюулгүй байдлын хамтын манлайлал нь дэлхийн шинэ дэг журамд бүтцийн хувьд голлох үүрэг гүйцэтгэж чадахгүй нь бололтой.

2.НҮБ-ын яриа хэлэлцээр, тохиролцооны ач холбогдол

НҮБ-ын яриа хэлэлцээний ач холбогдол гэдэг нь улсууд зөвхөн НҮБ-ын хүрээг ашиглахыг хүсэж, тохиролцооны үр дүнг үндэсний хэмжээнд зөвшөөрч чадвал тэр ач холбогдол нь болно.

НҮБ нь хэдэн мянган бага хурал хийж, хороо комисс байгуулж, тунхаглал, зөвлөгөө, конвенци боловсруулж, улсуудын өөрсдийн хүсэл зоригтой холбоотойгоор албадлагагүйгээр соёрхон баталж нэгдэхийг уриалдаг. Гэтэл НҮБ-ын үйл ажиллагаа нь аюулгүй байдлын асуудалд голлох үүрэг гүйцэтгэдэггүй. Зарим чухал гэрээ хэлцэл НҮБ-ээс гадуур хэлэлцэгдэж байв. Тухайлбал биологийн болон химийн зэвсгийг хориглох тухай конвенциуд. Гэтэл энэ хоёр гэрээ нь үнэндээ АЗ-ийн орнуудын цөмийн зэвсэг нь тодорхой хэмжээгээр өөрийн улс болон сөргөлдөгч улсынхаа энх тайван, аюулгүй байдалд заналхийлж буйг хамтаар хянах явдлыг нуун далдалж, цөмийн зэвсгийн засаглалыг хүлээн зөвшөөрүүлж, мөнхжүүлэх оролдлого байсан. Цөмийн зэвсгийг хориглох, хорогдуулах бүхий л чухал үйл ажиллагааг НҮБ-ын гадуур тохиролцсон⁷ (SALT, START).

Мөн эдийн засгийн аюулгүй байдал, худалдааны бодлогын салбарт улсууд НҮБ-ын хүрээнд институтчилэгдсэн гэх боловч үнэн хэрэгтээ Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-д тусдаа бие даасан асуудал болдог. Хэдийгээр Дэлхийн Банк, ОУВС нь бие даасан байгууллагууд боловч НҮБ-тэй холбогдож байх эрх зүйн үндэстэй. Гэвч эдгээр байгууллагууд нь Ерөнхий ассамблейд **шууд**

холбогдохоос цэрвэж байдаг. Энэ системд Атлантын давамгайлал, мөн тэдний мэдлийн Дэлхийн Банк, ОУВС, НАТО-гийн бодлого НҮБ-ын “эсрэг” хэрэгжсээр л байна.

Одоогийн шинэчлэлийн байдал НҮБ-ын дотоод байдалд чиглэж, НҮБ-ыг өргөтгөх бус үйл ажиллагааг нь хумьж ялангуяа тусламжийн онцгой байгууллагуудын үйл ажиллагааг хянах бодлого явж байна. НҮБ бол жижиг цомхон илүү сайн зохион байгуулагдсан үр бүтээлтэй байх хэрэгтэй. К.Аннан гарч ирээд захиргааны зардлаас гадна онцгой болон тусламжийн байгууллагын тоог багасгахыг бодсон. НҮБ-ын хэлэлцэж буй хэдэн мянган асуудал нь ихэвчлэн туслах чанартай байдаг. НҮБ-ын тохиролцооны систем нь эерэг, хүч хэрэглэхийг багасгасан, үр дүнтэй харилцан нөлөөлөл бий болгодог систем (Rittberger, 1997) гэж үзэх нь одоо утопи маягтай болсон (Link 2001). Хямралыг арилгахын тулд НҮБ-ын дэмжсэн, мөн зуучилсан хамтын ажиллагаа нь НҮБ-ээс гадуур шийдсэн хямралыг бодвол асуудлыг эв зүйгээр шийдэх магадлал багатай. Учир нь нэг талаас хямралыг шийдэх арга ажиллагаанаас үүдсэн хамтын харилцаа улсуудын хооронд таагүй байдал үүсгэнэ нөгөө талаас НҮБ-ын хүрэн дэх хямралыг шийдэх хэсэгчилсэн хамтын ажиллагааны хүчинд итгэх явдал багассан.

Эцэст нь тодруулж хэлэхэд их гүрнүүд өөрсдийн улс төрийн болон улам бүр нэмэгдэж буй эдийн засгийн асуудлаа НҮБ-ын хүрэнээс гадуур G-7, G-8-ын хүрээнд шийдвэрлэдэг хандлага улам бүр нэмэгдэж байна.

Эдгээрээс үзэхэд НҮБ-ын ирээдүйн тохиролцооны бодлогын ач холбогдлыг үндсээр нь өөрчлөх магадлал бага байна.

3.НҮБ-ын АЗ-ийг өргөжүүлэн шинэчлэх нь:

АЗ-ийг өргөтгөх хэдэн хувилбар (Потсдамын бага хурал 2001) байгааг доор дурдвал:

1. Америк хувилбар:

а) Герман, Япон мөн гуравдагч ертөнцийн 4 оронг НҮБ-ын АЗ-д шинээр оруулах, харин шинэ гишүүд нь хориг тавих эрхгүй байна (R.Holbrooke). 1994 оны 3 дугаар сард Вашингтонд сенат шийдэхдээ хэрэв дээрх хоёр улс нь НҮБ-ын цэрэг зэвсгийн ажиллагаанд бүрэн оролцоогоор оролцохыг зөвшөөрвөл АЗ-д орох асуудлыг дэмжинэ гэсэн⁸

- б) Америк санал болгохдоо байнгын 5 гишүүн ба гуравдагч ертөнцийн орнуудын хооронд баланс барих хэрэгтэй. Америк гуравдагч орны хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч санал хураалт үр дүнгүй болж тохиролцоонд хүрэхгүй байж болзошгүй гэж болгоомжилж байна. Гуравдагч ертөнцийн орнуудаас сонгохдоо хүн амынх нь тоог харгалзан үзэх хэрэгтэй гээд Америк 21 ба 24 гэсэн хувилбарыг авч үзсэн. Одоогийн 15 гишүүн улс + Герман, Япон, Канад, Итали + гуравдагч ертөнцийн 5 орон = 24 улс гэсэн хувилбар⁹ (Luman 2000) дэвшүүлжээ. Гуравдагч ертөнцийн орнуудыг ээлжлэх замаар оруулна. Мөн АЗ-ийн орнууд нь бусдаас илүү татвар төлөх учиртай гэсэн байр суурь барьдаг.
2. НҮБ-ын 51 дүгээр чуулганы дарга асан Razali-ийн 15+9 хувилбар: Одоогийн 15 гишүүн улс дээр 5 байнгын, 4 байнгын бус гишүүн авах бөгөөд шинэ гишүүд нь мөн хориг тавих эрхээс татгалзаж, одоогийн байнгын 5 гишүүн АНУ, Их Британи, Франц, Орос, Хятад улсууд зөвхөн тодорхой, онцгой тохиолдолд хориг тавих эрх эдэлнэ гэсэн хувилбар.
 3. 15+24 гэсэн Итали хувилбар: хязгаарлагдмал, оноолтын журмаар сонгогдсон 10 улс нь semi(хагас)-байнгын суудалтайгаар дунд зэргийн хөгжилтэй улсуудаас элсүүлэх хувилбар.
 4. quasi(хэлбэр төдий)-байнгын суудлын хувилбар: шинэ байнгын гишүүдэд хэлбэр төдий байнгын суудал олгох ба мөн хориг тавих эрхгүйгээр сонгох, харин байнгын бус гишүүн улсуудыг хуучны адил сонгуулиар элсүүлэх хувилбар.
 5. Зөвхөн байнгын бус гишүүдээр АЗ-ийг өргөжүүлэх хувилбар гэсэн төслүүд байна.

Германы шинэ Засгийн газар (SPD-Grünen) 1998 оноос хойш Razali хувилбарыг дэмжсэн байр суурьтай байна. АЗ-д ороход тэд энэ санал дээр буулт хийж болох талтайг ч зарим судлаачид үгүйсгэсэнгүй¹⁰ (Volger 2001). Хориг тавих эрхийг үгүй болгоно гэдэг бол бүтэшгүй асуудал харин түүнийг өргөжүүлэх хэрэгтэй гэсэн хатуу байр суурь байдаг. (Norman Peach) Үүнийгээ ч байнгын гишүүд илэрхийлсээр байна. Одоогийн АЗ-ийн гишүүн ОХУ-ын хувьд ямар ч үед түүний хориг тавих эрх нь үл хөндөгдөх бол АЗ-ыг өргөтгөх асуудлыг дэмжихэд бэлэн¹¹ (S.Lavrov 2003). Шинэ байнгын гишүүд вето эрхтэй байхыг Франц зарчмын хувьд дэмжиж болно¹² (J.Chirac,

2000) гэсэн найдвар төрүүлж байна. Гуравдагч ертөнцийн орнуудаас байнгын ба байнгын бус гишүүдийг сонгохдоо хөгжингүй орнуудтай баланс барьж сонгохыг Америк илүүд үзэж байна (Luman JGCB 2000). Бушийн засаг захиргаа сүүлчийн сонгуулиас хойш Германы болон уг асуудлаархи байр сууриа илэрхийлээгүй байна.

Анх удаа Герман улс нь энэ оны /2003/ эхээр НҮБ-ын АЗ-д Америкаас ангид дипломат алианц туршиж үзсэн. Энэ үйл явдал нь их гүрнүүдэд гадаад бодлогоо дахин шинэ нөхцөл байдалд уялдуулан шинэчлэн харах дохио өгөв. 2003 оны 1 дүгээр сарын 22-нд Франц, Германы төрийн удирдлагууд Европын удирдлагын дуо (duo) буюу хослол гэсэн томъёолол гаргасан. Хуучин Европын холбооны улсууд хоорондоо илэрхий холбоотон болсон ч шинээр элсэж буй Зүүн Европын улсуудыг үүндээ багтааж чадахгүй юм. Европын Холбоо нь АНУ-ын эсрэг гадаад бодлого, аюулгүй байдлыг зохицуулах нэгж болж жинхэнэ утгаараа чадахгүй. Атлантын Европ эсвэл Европын Европ гэсэн трансатлантын бодлогын хямрал үргэлжилсээр байна.

4.Герман улсын НҮБ-д чиглэсэн гадаад бодлого

1991 онд НҮБ-д чиглэсэн бодлого эрхэлсэн дэд хороо Бундестагт байгуулагдсанаас эхлээд өнөөг хүртэл гаргасан зарим судалгааны ажлууд¹³, бага хурлын материалууд, Потсдамын бага хурлын тунхаглал зэргээс үзэхэд Герман улсын НҮБ-д чиглэсэн гадаад бодлого доорх хандлагатай байна:

1. Герман улс нь НҮБ-ын АЗ-ийн байнгын гишүүн болоход хүчин *чармайлт* мөн *тэвчээр* гаргах хэрэгтэй: НҮБ-ын олон талт арга хэмжээнд оролцдог, 55 жилийн дотор эдийн засаг, хүн ам, цэрэг, улс төрийн хүчин чадлаар тэргүүлэх улс болсон. Герман улс нь хориг тавих эрхийг шинэчлэхэд нөлөөлөхөд бэлэн байх ёстой. АЗ-ийн одоогийн улсууд нь хориг тавих эрхээсээ татгалзахыг үл хүсч, мөн ирээдүйн АЗ-ийн гишүүн оронд вето эрх эдлүүлэхгүй байх магадлалтай. Мөн гуравдагч ертөнцийн ямар улс Герман ба Японтой АЗ-д орохыг судалж зорилгодоо тууштай хандах хэрэгтэй.
2. Энхийг сахиулах хүчинд идэвхитэй хувь нэмэр үзүүлэх: АЗ ба түүнээс мандатчилагдсан энхийг сахиулах **ажиллагааг** тогтвортой байлгах мөн энхийг сахиулах хүчний мандатыг

хэрхэн хуваарилах, ямар арга хэмжээ авахыг заадаг шинэ журмыг бий болгохын төлөө ажиллах:

НҮБ-д дутагдалтай байдаг өндөр мэргэшсэн техникийн болон тээвэрлэлтийн тусгай сүлжээ бүхий нэгтгэлүүдийг Германы зүгээс оруулах. Энэ хүрээнд мөн НҮБ-ын хүмүүнлэгийн ба тусгай байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг болж хэрэгцээтэй байгаа газарт ажиллах (гүүр, сургууль, цэцэрлэг г.м). НҮБ-ын дүрмийн 8 дугаар бүлгийг харгалзан үзэж энхийг тогтоох арга хэмжээнд НАТО мэтийн бүс нутгийн байгууллагыг цаашид улам идэвхитэй татан оролцуулахад чармайлт гаргах.

3. НҮБ-д Европын Холбооны бүрэн төлөөллийг бий болгох: Их Британи, Франц хоёр АЗ-д Европыг төлөөлж чадахгүй байгаа тул АЗ-д орох асуудлаар Европын дэмжлэгийг олох (2002 оны 6 дугаар сарын 28-29 Потсдамын бага хурал).
4. Герман улс нь НҮБ-ын санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд нэмэр болох ёстой. Герман улс салбар яамдынхаа хүрээнд дунд хугацааны туршид сайн дураараа өндөр татвар НҮБ-д хураалгах хөтөлбөрийг дэмжих, мөн Европын Холбоотой хамтран НҮБ-ын санхүүгийн хямралыг шийдвэрлэхийн тулд сайн дурын хандив өргөх систем бүхий санхүүгийн шинэ хөтөлбөр зохиох:
 - ❖ А. Төлөх ёстой бүрэн татварыг санхүүгийн жилийн эхний сар тутамд төлөх
 - ❖ Б. Өөрийн татварыг сайн дураар хэр их нэмэрлэж болох талаар судлах (энгийн ба энхийг сахиулах зардал)
 - ❖ В. Герман улс өөрийн сонгосон НҮБ-ын тусгай хороодын үйл ажиллагаанд татвар нэмэрлэх боломжийг нэмэгдүүлэх.
 - ❖ Г. НҮБ-ын санхүүгийн хүчин чадлыг бэхжүүлэх томоохон төсөл зохиоход оролцох
 - ❖ Д. Санхүүгийн зардлын тогтолцоог нээлттэй байлгахыг хичээх.
5. Хүний эрх нь эдийн засаг, нийгэм соёлын хөгжил ба олон ургальч ардчиллыг байгуулах, хадгалах нөхцөл гэдэг үүднээс нь дэлхий дахинаа хэрэгжүүлэхийг Герман улс хичээх. Германы хүний эрхийн институт (DMRI) байгуулагдаж зорилгоо доорх байдлаар тодорхойлсон:

- ❖ А. Хүний эрхийн тухай гэрээний заалтуудаас хүний эрхийг хөндөгч зүйлсийг судлах
 - ❖ Б. Хүний эрхийн гэрээг хэрэгжүүлэхэд нөлөөлөх
 - ❖ В. Хүний эрхийн дээд комиссарын газрыг хүн хүч, санхүүгийн чиглэлээр бэхжүүлэх (өөрийн сайн дурын санхүүгийн үйл ажиллагаагаараа)
6. Герман улс нь дэлхийн эдийн засгийн чухал улс тул дэлхийн шинэ дэг журмын бодлогод хамтран оролцох (Global governance). Герман нь зах зээлийн эдийн засгийн дэлхийн загварыг боловсруулахад оролцоогоо нэмэгдүүлэх, экологи, худалдаа, өрсөлдөөн, валют, санхүү, нийгэм, байгаль орчны салбарын механизм, мөн дэлхийн шинэ дэг журмыг байгуулах ба хөгжүүлэхэд оролцох. Дэлхийн банк, ОУВС, Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ), G-7/8-ыг агуулга, бүтцийнх нь хувьд НҮБ-ын системтэй маш ойр холбоонд байлгах бодлогыг Герман улс баримтлах ёстой.
7. Герман улс нь өөрийнхөө НҮБ-д чиглэсэн бодлогоо тодорхойлох: НҮБ-д чиглэсэн бодлого эрхэлсэн Бундестагийн кабинет доод шатандаа Гадаад яамтай хамтран жил бүрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Чуулганаас өмнө хурал зохион байгуулж байх. НҮБ-ын бага хурлуудад Бундестагийн парламентын гишүүдийг оролцуулж байх, Гадаад яам Бундестагийн даалгавраар жил бүр НҮБ-д чиглэсэн бодлогоо хуралдаанаар хэлэлцүүлж байх.
8. Герман улс нь хүний нөөцийн бодлогын хувьд идэвхтэй оролцож байх:¹⁴ Бундестаг нь НҮБ-ын Нарийн бичгийн дарга нарын газарт ажиллах чадварлаг мэргэжилтнүүдийг Германаас илгээх хэрэгтэй. Дунд болон түүнээс дээш албан тушаалд ажиллах мэргэжилтнийг Гадаад яамнаас төлөвлөгөөтэйгээр үр дүнтэй бэлтгэх, Герман улс нь татвар төлөгч гурав дахь том гүрэн боловч Нарийн бичгийн дарга нарын газар, дундаас дээш тушаалд ажиллаж буй Германы иргэд тэнд ажиллагсдын 5,1%-ийг эзэлж байгаа нь чамлалттай үзүүлэлт бөгөөд нийгмийн хангамжийн системээр урамшуулан дэмжих мөн буцаж ирснийх нь дараа өсөх боломжийг баталгаажуулж, цалин, хүүхэд, гэр бүлийн асуудлыг шийдэх.
9. Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд Герман улс хөгжлийн бодлогыг дахин авч үзэх хэрэгтэй ба шилжилтийн үеийн эдийн

засагтай орнуудад төвлөрүүлж, хөгжлийн доогуур төвшинтэй улсуудтай хоёр ба олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх хэрэгтэй ч хөрөнгө санхүү дутагдсаар байна. 1992 онд НҮБ-ын Байгаль орчин, хөгжлийн бага хурлаар ДНБ-ий 0,7%-ийг санхүүгийн арга хэрэгсэл болгохоор тогтоосон ч Германы хувьд 0,2%-тай байна. Хөгжлийн тусламжийн хүрээг зөвхөн зах зээл, эдийн засаг гэж хязгаарлах бус энх тайван, аюулгүй байдлын бодлоготой уялдуулахыг чухалчлах.¹⁵ (Hedrich)

10. Иргэний нийгмийн оролцоог Германд дэмжих, НҮБ-ын хүрээний бага хурал, түүнд бэлтгэх, хамтран зохион байгуулах, хэрэгжүүлэх хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцсоноор Германы төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлнэ¹⁶. (Rittberger, Brühl)
11. Иргэд НҮБ-ын үйл ажиллагаааны талаар мэдлэгтэй байх хэрэгтэй. НҮБ-ын мэдээлийн төвүүдийг хүн хүч, санхүүгийн бодлогоор дэмжиж уялдаа холбоотой байх. НҮБ-ыг улс төр, эдийн засаг, олон улсын эрх зүйн судалгаатай холбосон энх тайван, хямралыг зохицуулах агуулгатай судалгааны ажлыг их сургуулиудад дэмжих.
12. Залуучуудыг НҮБ-ын ажилд оролцох сонирхол бололцоог дэмжих. National Model United Nations хөтөлбөрүүдэд ороход нь дэмжих. Сургуулийн ном, хичээлийн төлөвлөгөөнд оруулах, НҮБ-д ажиллах дадлага хийхэд зуучлах гэх мэт.

Дүгнэлт

1973-2003 он бол Германы НҮБ дэх гишүүнчлэлийн түүх бөгөөд уг 30 жилийн сүүлийн 12 жил нь нэгдсэн Германы идэвхитэй бодлогын үе байсан. Ийм идэвхитэй бодлого явуулах зайлшгүй шаардлагатай байсан нь нэгдүгээрт хүйтэн дайн дууссан ч үйлдвэрлэл, худалдаа, эдийн засгийн хүчирхэг гүрэн дэлхийн засаглалд оролцоход, хоёрдугаарт G8-ийн нэг болохын хувьд шийдвэр гаргах үйл явцад оролцоход Германы НҮБ дэх статус хангалтгүй байсантай шууд холбоотой юм. Мөн энэ үе нь НҮБ гэдэг дэлхийн шинжтэй цорын ганц байгууллага өөрөө гишүүдийнхээ үүсгэсэн хямралын галыг унтраах хүчин мөхөс болсон цаг үетэй давхцана.

1991 оноос НҮБ-д чиглэсэн бодлого Германд төрийн дээд хэмжээний асуудал болсон бөгөөд тэрээр дээр дурдсан зорилтуудыг өмнөө тавьсан ч санхүүгийн болон дипломатын бэрхшээл байсаар байна. Анх 1994 онд Германыг АЗ-д элсүүлэх санал гарч НҮБ-д гишүүдийн дэмжлэгийг олж авч чадаагүй нь тухайн үеийн улсуудын үндэстэн улсын нийгмийн сэтгэхүй ба НҮБ-ыг шинэчлэх арга замын талаарх төсөөлөл ач холбогдол бага байсантай байв. Харин өнөөгийн нөхцөлд улсууд АЗ ба түүний хамтын манлайллын системээр хэрэгждэг аюулгүй байдал, ирээдүйн дэлхийн шинэ дэг журамд хараахан чухал үүрэг гүйцэтгэж чадахгүйг ойлгож эхэлсэн болов уу.

Германыг НҮБ-д дэмжих асуудал 1. үндэстэн улсуудын, 2. АЗ-ийн байнгын 5-ын, 3. НҮБ-ийн дүрмийг шинэчлэх шаардлагын хүрээнд тавигдана. Тэгэхээр энэ нь зөвхөн хэдэн улсаар гишүүнчлэлээ нэмэх бус системийн шинэчлэлийн түүхэн, шинэ дэг журмын асуудал болох юм.

АЗ-ийн гишүүдээс юутай ч ОХУ, Франц хоёр Германыг дэмжих байр сууриа илэрхийлж байна. АНУ-ын хувьд Иракийн хямралаар үүдсэн таагүй уур амьсгал, трансатлантын бодлогын хувь заяаг Герман улс хэрхэн төсөөлж буй бодлого, Америкийн Номхон далайн бүс нутгийн давамгайллын бодлогод хандах Европын байр суурь, мультилатерализмыг дэмжигч бодлого зэргээс үүдэн хараахан Германыг дэмжихгүй байна. Гэвч Германы болон Европын гадаад бодлогын тэнцвэр алдагдахаас болгоомжилсон үзэл санаа сүүлийн үед яригдах болсон тул дээрх хямрал намжина гэдэг нь ойлгомжтой.

Герман улсын их хэмжээний хүмүүнлэгийн болон хөгжлийн тусламж, хүний эрхийг хангах байр суурин дээр баттай зогсдог,

иргэний нийгмийг дэмжиж, олон улсын харилцааны оролцогчид болох засгийн газрын бус байгууллагуудыг дэмжихэд ач холбогдол өгдөг гэх мэт эерэг бодлогыг үндэслэн, Германд таатай НҮБ-ын шинэчлэлийн үйл явц эхэлтэл 10 жил л байна хэмээн өөдрөгөөр үзсэн судлаачид ч байна.

Үүний хажуугаар дэлхий дээр энхийг тогтооход Герман улс бодитой, хүчтэй үйл ажиллагаа явуулж чадахуйц их гүрний хувьд их хариуцлага хамгийн гол нь итгэл хүлээх учиртай хийгээд 1998 онд Социалдемократ Намын эвсэл сонгуульд ялахад Гадаад яамны сайд Ё.Фишер, (Г.Шрёдер НҮБ-ын шинэ зууны чуулган дээр мөн үүнийг баталж хэлсэн) *"НҮБ-ыг бэхжүүлэх үйлсэд Германчуудаас илүү итгэлтэй холбоотон НҮБ ба түүний гишүүн орнуудад олдохгүй гэдэгт итгэж болно"* гэж хэлснийг дахин дурдмаар байна.

Мөн дэлхийн эдийн засгийг фундаментчилахад тэмүүлж буй неолебирал баян улсуудын клубын идэвхитэй том гишүүн, Засгийн газар нь либеральчлалыг хэрэгжүүлэхдээ бодлогын болон мөн чанарын хувьд эдийн засгийн тэнцвэржилт, хамгаалалтын механизмыг урьтал болгодог. Дэлхийн эдийн засгийн хандлагын хүндийн төвийг өөрчлөн ойлгуулахад НҮБ-ыг ашиглахыг дэмжсэн бодлого барьж байна гэж шүүмжилсэн¹⁷ (WEED Report, Martens) хэсэг ч байна.

Юутай ч Германы НҮБ-д чиглэсэн бодлогыг ирээдүйн олон улсын харилцааны дэг журмыг хамтран зохиолцох, global governance-д их гүрнүүдийн нэгэн адил үүрэгтэй байхыг зорьж буй үйл явдал гэж томъёолж болохоор санагдана.

Ишлэл

1. Thomas Nielebock/Volker Rittberger. Die japanische und deutsche Aussenpolitik in vergleichender Perspektive, Ein Tagungsbericht. In: Zeitschrift für Internationale Beziehungen 1999, 1; S. 147-161
2. Manfred Knapp
http://www.bpb.de/publikationen/JL01ZZ,1,0,Die_Rolle_der_Vereinten_Nationen_in_der_internationalen_Politik.html#art1
3. Vereinte Nationen 1993. United Nations General Assambly A/48/264, 20.07.1993; Questions of Equitable Representation on and Increase in the Membership of the Security Council. Report of the Secretary-General
4. Ernst-Otto Czempel; Die Reform der UNO. Möglichkeiten und Mißverständnisse. 1994 S.58-62

5. Vereinte Nationen 1993. United Nations General Assambly A/48/264, 20.07.1993; Questions of Equitable Representation on and Increase in the Membership of the Security Council. Report of the Secretary-General
6. Werner Link; Die Neuordnung der Weltpolitik. Grundprobleme globaler Politik an der Schwelle zum 21. Jahrhundert 2001 S. 115
7. ebenda. S. 121-126
8. USIA Wireless file 1994.02.08 p.3
9. Lyman. US Ambassador to UN. Bericht der Konferenz: The United Nations In the 21st century: Japanese, German and US Perspectives. 21-22.09.2000
10. Helmut Volger. Bericht der Potsdamer Konferenz 22. Januar 2001
11. S.Lavrov. G8 statt UNO? Russland, die USA und die Vereinten Nationen in: Wochenzeitung Freitag. 02.05.2003
12. Jacques Chirac Rede von Staatspräsident zur Reform des Sicherheitsrats der Vereinten Nationen. Generalversammlung der Vereinigten Nationen zum Millenniumsgipfel New York, 7. September 2000
13. Globalisierung der Weltwirtschaft; Herausforderungen und Antworten. Zwischenbericht der Enquete-Kommission. Sonderausgabe für die Bundeszentrale für politische Bildung, Bonn 2001
14. Klaus Hüffner. UNESCO-Forum. Gibt es eine deutsche Personalpolitik im VN-System? Berlin 04.12.2000
15. Klaus Jürgen-Henrich. Bericht der Potsdamer UNO-Konferenz 2002
16. Tanja Brühl., (Hrsg). Die Privatisierung der Weltpolitik. Entstaatlichung und Kommerzialisierung im Globalisierungsprozess 2001
17. Bericht von Jens Martens. In: UN-williges Deutschland. Der WEED-Report zur deutschen UNO-Politik. Eine-Welt-Texte der Stiftung Entwicklung und Frieden Bd.3 Bonn 1997

Ном зүй

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм
2. Ernst-Otto Czempel; Die Reform der UNO. Möglichkeiten und Mißverständnisse. 1994
3. Edited by Volker Rittberger; German foreign policy since unification. Theories and case studies 2001
4. Edited by Volker Rittberger; Global governance and the United Nations system 2001

5. Tanja Bruehl., (Hrsg). Die Privatisierung der Weltpolitik. Entstaatlichung und Kommerzialisierung im Globalisierungsprozess 2001
6. Werner Link; Die Neuordnung der Weltpolitik. Grundprobleme globaler Politik an der Schwelle zum 21. Jahrhundert 2001
7. Volker Rittberger; Internationale Organisationen. Politik und Geschichte 2. Auflage 1995
8. Edited by Muthiah Alagappa and Takashi Inoguchi; International security management and the United Nations 2001
9. Globalisierung der Weltwirtschaft; Herausforderungen und Antworten. Zwischenbericht der Enquete-Kommission. Sonderaufgabe für die Bundeszentrale für politische Bildung, Bonn 2001
10. Thomas Nielebock; Die japanische und deutsche Aussenpolitik in vergleichender Perspektive. Ein Tagungsbericht. In Zeitschrift für Internationale Beziehungen Nr.1/1999 S.147-161
11. Vereinte Nationen 1993 United Nations General Assambly A/48/264, 20.07.1993; Questions of Equitable Representation on and Increase in the Membership of the Security Council. Report of the Secretary-General
12. Vereinte Nationen; "Internationale Solidarität und Eigeninteresse - deutscher UN-Politik an der Schwelle zum nächsten Jahrhundert" Namensartikel des Staatsministers im Auswärtigen Amt Dr. Ludger Vollmer. Ausgabe 02/99
13. UN-williges Deutschland. Der WEED-Report zur deutschen UNO-Politik. Eine-Welt-Texte der Stiftung Entwicklung und Frieden Bd.3 Bonn 1997
14. Agenda für Frieden; Agenda fuer Entwicklung; Deutsche Übersetzung. www.uno.de
15. <http://www.forschungskreis-vereinte-nationen.de/> Memorandum für eine engagierte VN-Politik Deutschlands 2001
16. The United Nations in the 21st Century: Japanese, German and US Perspectives. In Document of Conference by the Japanese-German Center Berlin (JGCB) and The Japan Institute of International Affairs (JIIA) on September 21-22, 2000 Berlin
17. http://www.auswaertiges-amt.de/www/de/aussenpolitik/vn/vereinte_nationen/index.html
18. http://www.fsk.ethz.ch/documents/beitraege/zu_35/zu35_ch1.htm

19. http://www.parlament.ch/afs/data/d/gesch/1997/d_gesch_19973466.htm
20. <http://www.uni-kassel.de/fb10/frieden/themen/UNO/paech.html>
21. <http://www.uni-kassel.de/fb10/frieden/regionen/Russland/laworow.html>
22. http://www.bpb.de/publikationen/JL01ZZ.1.0.Die_Rolle_der_Vereinten_Nationen_in_der_internationalen_Politik.html#art1
23. <http://www.dgvn.de/pdf/polpap5.pdf>. DGVN-Policy-Paper-No5 26.03.2002 Für eine internationale Kultur der Prävention" und eine Politik des globalen Gemeinwohls Vorschläge und Forderungen der DGVN an die deutsche UN-Politik
24. Volker Weyel Der Politik ein kritisch-konstruktiver Begleiter in: Das Parlament Nr. 13 - 14 / 2./5. April 2002
25. Hans-Peter Schwarz; Die Gleichgewichtsstörung deutscher Aussenpolitik in: Internationale Politik . Mai 2003 Nr. 5 S. 79-80
26. Gernot Erler Grundsätze für deutsche Aussenpolitik nach dem 11. September 2001 in: Internationale Politik und Gesellschaft Online 3/2002.